

**ОЛОН УЛСЫН ХАМТЫН  
АЖИЛЛАГААГ ШИНЭ  
СЭТГЭЛГЭЭГЭЭР  
ХӨГЖҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ**

Зөвлөлт Холбоот Улсын Коммунист намын XXVII их хурлаас зөрчилтэй боловч харилцан холбоотой, харилцан шүтэлцээтэй, уг чанартаа бүхэл бүтэн ертөнцийн тухай үзэл баримтлал боловсруулж, олон улсын хамтын ажиллагааг үзэл суртлаас ангижруулж шинэ сэтгэлгээгээр хөгжүүлэх талаар гаргасан заалтыг Зөвлөлт Холбоот Улс тууштай хэрэгжүүлж байна. ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗХУ-ын Дээд Зөвлөлийн дарга М. С. Горбачевын энэ онд БНХАУ, Куба, Англи, Франц, ХБНГУ-д хийсэн айлчлал нь Зөвлөлт Холбоот Улс болон дээрх орнуудын харилцаа, олон улсын хамтын ажиллагааг шинэ сэтгэлгээгээр өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгой ач холбогдолтой түүхт үйл явдлууд боллоо.

Зөвлөлтийн удирдагч М. С. Горбачев дөрөвдүгээр сард Кубад найрсгаар айлчилсан нь ЗХУ, Кубын ах дүүгийн найрамдалт харилцааг цаашид улам бүр бэхжүүлж хөгжүүлэхэд асар их ач холбогдолтой болов. М. С. Горбачев Кубын удирдагчтай ярилцаж, хэлэлцээ хийхдээ хоёр талын хамтын ажиллагаанаас гадна Латин Америк, нийт дэлхий дахины байдалтай хамаатай өргөн цар хүрээтэй асуудлыг хамарлаа. Зөвлөлт, Кубын найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээнд М. С. Горбачев, Фидель Кастро нар гарын үсэг зурав. М. С. Горбачевын хэлсэнчлэнгээр уг баримт бичиг нь цаг үеийн сорилт шалгалтыг нэгэнт даван туулсан тэр бүхнийг бататгахын сацуу Зөвлөлт, Кубын улс төр, эдийн засаг, соёлын хамтын ажиллагаанд шинэ хэтийн төлөв нээлээ.

Кубад Зөвлөлтийн удирдагчийн хийсэн айлчлал хоёр орны хүрээгээр үл хязгаарлагдах бөгөөд Латин Америкийн ард түмэнтэй ЗХУ эв санааны нэгдэлтэй байгаагийн илрэл, тэндэх бүс нутгийн асуудлыг бүхэлд нь зохистой шийдвэрлэж, хөгжиж буй орнуудын тусгаар тогтнолыг бэхжүүлж шударга тэмцлийг нь ялалтад хүргэхэд түлхэн үзүүлэхүйц түүхэн үйл явдал боллоо.

Мөн сард М. С. Горбачев Их Британид албан ёсны айлчлал хийв. Энэ удаад Их Британид Михаил Горбачевын хийсэн айлчлал нь өрнө, дорно гэж эрс ялгаж зааглаж байсан цагийнхаас, зогсонги байдлын үеийнхээс олон талаар ялгарч онцгой сонин содон, ил тод, үр ашигтай болсныг зориуд дурдалтай. М. С. Горбачев «...Олон арван жил үргэлжилсэн «хүйтэн дайн» дорнодод ч, өрнөдөд ч дэндүү их хохирол учруулсан. Бид манай гаригийн улс төрийн уур амьсгалыг үндсээр нь өөрчлөхгүйгээр зэвсгийг жинхэнэ ёсоор гүн гүнзгий хурааж чадахгүй» гэлээ. Энэ оны нэгдүгээр сарын нэгний байдлаар зөвлөлтийн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн 4 сая 258 мянган хүнтэй байсныг хорогдуулж, 1990 оны эцэс гэхэд 3 сая 760 мянган хүнтэй болгоно. Цэргийн зориулалт бүхий дээд зэргийн баяжилттай уран үйлдвэрлэхийг энэ онд зогсоохоор шийдвэрлэлээ. 1987 онд хаасан зэвсгийн зориулалттай плутони боловсруулах аж үйлдвэрийн реактор дээр нэмж энэ жил болон ирэх жил дахин хоёр тийм реакторыг хаах бөгөөд тэдгээрийг орлох шинэ хүч чадал ашиглалтад оруулахгүй гэж Михаил Горбачев мэдэгдсэн юм. Энэ нь зэвсэгт зориулсан задрагч материал

үйлдвэрлэхийг бүрэн хориглох чиглэлээр хийсэн бас нэг том алхам мөн. Хэрвээ аргагүй байдалд оруулахгүй бол ЗХУ цөмийн тактикийн зэвсгийг шинэтгэхийг эрмэлзэхгүй нь ч тодорхой боллоо. Зөвлөлтийн тэрхүү зоримог алхам, ухаалаг хандлага, ил тод байр суурьт монголын олон нийт баяр хүргэж байна. Энэчлэн тэрхүү шинэ санал санаачилгыг олон улс оронд оновчтой бодлого хэмээн талархалтай хүлээн авлаа.

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ ын Дээд Зөвлөлийн дарга М. С. Горбачевын БНХАУ-д тавдугаар сард хийсэн айлчлал нь ЗСБНХУ, БНХАУ-ын бүх талын харилцааны хөгжлийн шинэ шатны түүхэн эхлэлийг тавьж, Ази тив, даян дэлхийд итгэлцэл, энх тайван, тогтвортой байдлыг бататгах үйлсэд дорвитой алхам боллоо. Энэ айлчлалын үеэр нэн өргөн сэдвээр, үр бүтээлтэй хариуцлагатай яриа хэлэлцээ хийсэн нь «хуучнаа орхиж, ирээдүйгээ харах» зарчмын үндсэн дээр хоёр орны уламжлалт харилцааг сэргээн, цаашид улам бүр гүнзгийрүүлж, шинэ түвшинд гаргах онцгой ач холбогдолтой болов гэж хоёр тал санал нэгтэй дүгнэжээ.

Нутаг дэвсгэр, хүн ам, эдийн засгийн чадавхийн хувьд хамгийн том социалист хоёр орон, хоёр намын хооронд харилцаа хэвийн боллоо гэж мэдэгдэж болох байна гэж М. С. Горбачевтой ХКН-ын Төв Хорооны цэргийн зөвлөл, БНХАУ-ийн цэргийн Төв Зөвлөлийн дарга Дэн Сяопин уулзахдаа цохон тэмдэглэв.

Хоёр орны удирдагчид нээгдэж байгаа өргөн бололцоог ашиглан цаашид бүх салбарт хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх тодорхой асуудлуудад онцгой анхааран, орон тус бүрийн засгийн газруудад санал оруулж байх хэлэлцээний ажлын механизм бий болгох, хамтын ажиллагааг урт хугацааны үндэстэй болгон орчин үеийн шинэ хэлбэрүүдийг ашиглах, харилцаа хэвийн бус байсан үед газар авч аль алинд нь эдийн засаг, санхүүгийн ихээхэн дарамт учруулсан цэргийн талаар сөрөн зогсох зохисгүй байдлыг арилгахын тулд хилийн районд байрлалтай цэргийг хорогдуулахаар тохирчээ. Мөн БНМАУ-д байрлаж байгаа бүх цэргээ гаргахад ЗХУ бэлэн байгааг Зөвлөлтийн удирдагч илэрхийлснийг Хятадын удирдагчид сэтгэл ханамжтай хүлээн авсан байна.

БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлал бол бүх чиглэлд хамтран ажиллах ихээхэн боломж нээсэн эрин үеийн чухал үйл явдал мөн гэж М. С. Горбачев үнэлэв.

Зөвлөлт, Хятадын дээд хэмжээний уулзалт нь хоёр орны ард түмний язгуур эрх ашиг, хүсэл эрмэлзэлд нийцэж даян дэлхийд энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалахад тус дөхөм үзүүлж байна.

Михайл Горбачев ХБНГУ-д зургадугаар сард албан ёсны айлчлал хийв.

М. С. Горбачев ХБНГУ-ын канцлер Гельмут Коль нар найрсаг, илэн далангүй байдалд Европын үйл явц, дэлхийн хэрэг явдалд хоёр орны оруулах хувь нэмэр боломжийн тухай, бүх нийтийн аюулгүй байдал, Европ болон дэлхий дахины хэвийн хөгжилд Зөвлөлт, америкийн харилцааны нааштай хувь нэмэр нэмэгдэж байгаагийн ач холбогдол, орон бүрийн удирдлагын үнэнхүү санаа бодлыг зөв ойлгох нь чухал болох талаар санал солилцлоо.

Айлчлалын үеэр Зөвлөлтийн удирдагч болон холбооны канцлер Гельмут Коль нар хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурав. Түүнчлэн эдийн засгийн салбарт хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх, тухайлбал мэргэжилтэн, удирдах боловсон хүчин бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх талаар хамтран ажиллах тухай хэд хэдэн баримт бичигт гарын үсэг зуржээ.

Айлчлалын үеэр шинжлэх ухаан, дээд боловсролын салбарт хамтын ажиллагаа өргөжүүлэх тухай хэлэлцээр, ЗСБНХУ, ХБНГУ-ын соёлын төв байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны тухай хэлэлцээр, бусад хэд хэдэн баримт бичигт гарын үсэг зурав.

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ ын Дээд Зөвлөлийн дарга М. С. Горбачевын ХБНГУ-д хийсэн айлчлалын үеэр ЗСБНХУ, ХБНГУ-ын Гадаад явдлын яамны сайд нар химийн зэвсэг хориглох талаар хүч чармайлт тавих тухай мэдэгдэл гаргав. Хэвлэлийн бага хурал дээр энэ айлчлалыг ЗСБНХУ, ХБНГУ-ын харилцаанд төдийгүй бас Европын бодлогод ч, нийт дэлхийн бодлогод ч томоохон үйл явдал боллоо хэмээн үзэж түүний дүнг өндөр үнэлж байна гэж зөвлөлтийн удирдагч тэмдэглэв.

Михаил Горбачев долдугаар сард Францад айлчлав. М. С. Горбачевын Францад хийсэн айлчлал нь хоёр орны найрсаг харилцаа, бүх талын хамтын ажиллагааг улам бататган шинэ агуулга хэлбэрээр баяжуулж зохих хурдаар урагшлуулахад дорвитой түлхэц өглөө гэж зөвлөлт, францын болон дэлхийн олон нийт таашаан угтав.

Айлчлалын үеэр хийсэн яриа хэлэлцээний үр дүнд нийтдээ 22 баримт бичигт гарын үсэг зурав. Эдгээрийн дотор хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолборын салбарт шинжлэх ухаан, эдийн засаг, аж үйлдвэрийн талаар хамтран ажиллах 2000 он хүртэлх урт хугацааны программ, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр, сансрын уудмыг энхийн зорилгоор судалж эзэмших салбарт хамтран ажиллах тухай хоёр орны засгийн газар хоорондын 1966 оны зургадугаар сарын 30 ны хэлэлцээрийн протокол, мөн зөвлөлт, францын зэвсэгт хүчин 1990-1991 онд хамтран ажиллах тухай хоёр орны Батлан хамгаалах яамны хэлэлцээр орж байна. Москва, Парист соёлын төв байгуулах, түүний үйл ажиллагааны нөхцөлийн талаар тохиролцож, Кремль, Елисейн ордны хоорондын шууд харилцааны шугамыг боловсронгуй болгох, залуучуудын солилцоог өргөтгөх, улсын архивын салбарт хамтран ажиллах засгийн газар хоорондын хэлэлцээрүүд байгууллаа.

Хоёр талын харилцааг өргөжүүлж гүнзгийрүүлэхэд болон олон улсын ээдрээ маргаантай асуудлыг улс төрийн аргаар бүх нийтийн хүсэл тэмүүлэлд нийцүүлэн зохистой шийдэхэд зоримог, тодорхой алхам хийж бодитой хувь хандив оруулахыг зорьсон зөвлөлт, францын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ амжилттай боллоо.

Энэ оны долдугаар сард Бухарестэд болсон Варшавын гэрээнд оролцогч улсуудын улс төрийн зөвлөлдөх хорооны зөвлөлгөөнд оролцогчид Европт зэвсэг хураах, аюулгүй байдлыг хангах талаар шинэ шинэ арга хэмжээ авч хэрэгжүүлж, ард түмэн бүрийн нийгэм, эдийн засгийн дэвшлийг хангах, нийгмийн байгууллаас шалтгаалахгүйгээр Европын улсуудын хамтын ажиллагаа, эв нэгдлийг бэхжүүлэх, эрх чөлөөтэй, бие даасан орнуудын нэгдмэл Европыг төвхнүүлэхэд тус дөхөм үзүүлэх шинэ харилцааг бүрэн эрх тэгш үндсэн дээр тогтоох шаардлагатайг онцлон тэмдэглэв.

М. С. Горбачев энэ хурал дээр үг хэлэхдээ Европын ажил үйлс нэгэнт сайн тийшээ эргэсэн нь бодит баримт мөн. Улс төрийн шинэ сэтгэлгээний нөлөөгөөр бий болсон нөхцөл байдалд Варшавын гэрээнд оролцогч улсуудын олон чухал санаачилгыг хэрэгжүүлэх боломжтой боллоо гэж тэмдэглэв.

ЗХУ болон бусад социалист улсуудын идэвхтэй бодлого, энхийг эрхэмлэгч, бодитойгоор сэтгэгч бүх хүчний үйл ажиллагааны ачаар олон улсын үйл хэрэгт тодорхой нааштай ахиц гаргаж, түгшүүртэй байдал, сөргөлдөөнийг намжаан зөөлрүүлж, итгэлийг нэмэгдүүлж, улс төрийн яриа хэлцээг хөгжүүлэн улс орнуудын янз бүрийн түв-

шингийн хэлхээ холбоог эрчимжүүлж чадлаа гэж Варшавын гэрээнд оролцогч улсуудын улс төрийн зөвлөлдөх хорооны зөвлөлгөөнд оролцогчдын гаргасан албан мэдээнд тэмдэглэжээ.

Варшавын гэрээ, Умард Атлантын эвслийн харилцааг үл сөргөлдөх замд оруулж, улс төр, цэргийн салбарт хоёр эвслийн хооронд үр бүтээлтэй яриа хэлэлцээ хийж, энэхүү яриа хэлэлцээг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны хүчин зүйл болгохыг уриалав.

Варшавын гэрээнд оролцогч улсуудын дээд хэмжээний төлөөлөгчид Европ тивийг цөмийн болон химийн зэвсэггүй, тогтвортой, аюулгүй тив болгохын төлөө зэвсэгт хүчин, зэвсэглэл, цэргийн зардлыг үлэмж хорогдуулахын төлөө байгаагаар илэрхийлсэн нь дэлхий дахины байдалд нааштай нөлөөлж, дэлхийн хөгжлийн өнөөгийн хандлагад бүрэн нийцэж, олон улсын тавцанд улс орнууд сөргөлдөхөөс хамтран ажиллах, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд шилжин ороход тус хүргэх нь дамжиггүй.

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнх энэ оны долдугаар сард ЗХУ-д ажлын айлчлал хийх үеэр ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗХУ-ын Дээд Зөвлөлийн дарга М. С. Горбачевтай уулзаж ярилцахдаа, хоёр орны харилцааны болон олон улсын байдлын тулгамдсан асуудлаар санал бодлоо солилцож, хамтын үйл ажиллагааны цаашдын зарчмыг тохиролцсон нь манай орнуудын олон талт хамтын ажиллагааг чанарын шинэ шатанд дэвшүүлсэн чухал ач холбогдолтой үйл явдал боллоо.

Варшавын гэрээнд оролцогч улсуудын улс төрийн зөвлөлдөх хорооны Бухарестийн зөвлөлгөөний баримт бичигт тодорхойлсон заримын үзэл санаа, хандлагыг БНМАУ бүрэн дэмжиж байгааг нөхөр Ж. Батмөнх илэрхийлэв.

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ж. Батмөнх Халхын голын Ялалтын 50 жилийн ойн баярын хурал дээр хэлсэн үгэндээ Ази номхон далайн зүүн хойт хэсгийн орнуудын хооронд улс төрийн яриа хэлэлцээ хийх, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёл, боловсролын салбарт хамтран ажиллаж, экологийн талаар, мөн хүмүүсийн хоорондын холбоо харилцааны үр ашигтай механизм бий болгох тухай шинэ санал дэвшүүлсэн нь ЗХУ, БНХАУ болон бүс нутгийн бусад нэлээд орны дэмжлэгийг хүлээж байна. Энэ санал нь ЗХУ-аас Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар гаргаж буй удаа дараагийн санал, санаачилгад дүйж, тэдгээрийг улам урагш ахиулан, агуулгыг өргөтгөх боломжийг тодорхойлж байгаагаараа онцлог юм.

Энэ оны дөрөвдүгээр сард БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайд Ц.Гомбосүрэн Хятадад, мөн оны есдүгээр сард БНХАУ-ын Гадаад явдлын яамны сайд Цянь Цичэнь Монголд харилцан айлчилсан нь хоёр орны харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд болон ЗХУ-аас Ази Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар гаргаж буй санал, санаачилгыг хэрэгжүүлэхэд нэмэр хандив болов.

Олон улсын хамтын ажиллагааг шинэ сэтгэлгээгээр хөгжүүлэхийн төлөө ЗХУ-аас гаргаж буй хүчин чармайлт амжилтанд хүрч олон улсын байдалд нааштай өөрчлөлтүүд гарч байгаад монголын ард түмэн талархан баяр хүргэж байна.